

Орон бүхий, пролетариат нар нэгдэгтүн!

АНХДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
ж ндээ

№ 74 (2378)

1974 оны 10 дугаар сарын 3

ПҮРЭВ

УДААН ЖИЛИЙН ЗУЗААН НАЙРАМДАЛ

Монгол—Зөвлөлтийн ард түмний найрамдлын уламжлалт 23 дахь удаагийн сарын ажил манай орон даяар эхэллээ. Уламжлалт энэ сарын ажил МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой, Аугаа Их Октябрийн хувьсгалын 57 жилийн ой угтсан их хөдөлмөрийн өрнөлтийн үед тохиолдож байна.

Аугаа их В. И. Ленин, Д. Сүхбаатар нарын үндэс суурийг нь тавьсан тус хоёр орны ах дүүгийн найрамдал шинэ шинэ агуулгаар улам баяжиж манай хоёр ард түмний социализм, коммунизмын байгуулалтын үйлсэд гайхамшигт сайхан үр шимээ өгсөөр байна.

Манай орны социалист байгуулалтад ЗХУ-аас үзүүлж байгаа тусламж өгөөмөр их билээ. Монголын ард түмний амин чухал эрх ашиг, хүсэл эрмэлзлэлийг үнэнхүү сэтгэлээр угтан авч, ах дүүгийн халуун сэтгэлээс Зөвлөлтийн мэргэжилтнүүд тус аймгийн аж ахуй соёлын бүхий л салбарт биечлэн оролцож, нөхөрсөгөөр туслаж байдагт манай аймгийн хөдөлмөрчид чин сэтгэлийн талархал дэвшүүлж байна.

Сүүлийн жилүүдэд ЗХУ-ын хүч хөрөнгөөр тус аймгийн Эрдэнэсант, Баянцогт, Угтаалын САА—д багсармал тэжээлийн үйлдвэр, аж ахуй, Жаргалант, Угтаал, Баянцогтод үрийн механикжсан агуулах, Батсүмбэрийн САА-д трактор засварын газар, Баянцогтод өвч механикжсан үнээний ферм зэрэг олон тооны барилга байгууламж ашиглалтанд оруулсан зэрэг үнэлж баршгүй тусламж нь жинхэнэ интернационал шинж чанартай, ах дүүгийн сэтгэл харамгүй тусламж мөн.

Монгол—Зөвлөлтийн найрамдлын уламжлалт 23 дахь сарын үеэр ЗХУКН-ын XXIV их хурлаас дэвшүүлсэн коммунист бүтээн байгуулалтын лут их программыг хэрэгжүүлж байгаа Зөвлөлтийн ард түмний гайхамшигт ололт амжилт, хуримтлуулсан туршлага, манай хоёр орны ард түмний эвлэршгүй бат найрамдал, хамтын ажиллагааг харуулсан өргөн ажил зохиогдох ба ЗХУ-ын хөнгөн ба хүнсний үйлдвэрийн өдрүүд, найрамдалт Курган мужийг сурталчлах 7 хоног явагдах болно. Иймд Курган мужийн болон ЗХУ-ын хөнгөн ба хүнсний үйлдвэрийн хөгжилтийг харуулсан самбар үзэсгэлэн гаргах, шинэ техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж буй гарга туршлагыг судлан эзэмших, сурталчлах ажлыг өргөн зохиох нь чухал.

Мөн манай ард түмний эрх чөлөө, аз жаргалын төлөө хамтын тэмцэлд хатуужин бэхжсэн Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн элгэн халуун найрамдал, хамтын ажиллагааны яруу алдарт уламжлалаар нийт хөдөлмөрчдийг хүмүүжүүлэх, Зөвлөлтийн ард түмний коммунизмын байгуулалтын амжилтын тухай лекц яриа хийх, Зөвлөлтийн мэргэжилтнүүд ажиллаж байгаа газруудад багш шавийн чуулга уулзалт зохиох, хэвлэл ном, уран бүтээл болон улс ардын аж ахуйн тодорхой салбарын хөгжилтийг харуулсан үзэсгэлэн байгуулах киноны өдрүүд, найрамдлын үдэшлэг зохиох, түүхэн үйл явдлыг тэмдэглэх, асуулт хариултын болон биеийн тамирын уралдаан тэмцээн явуулах, орос хэл суралцах хөдөлгөөнийг өрнүүлэх зэрэг олон хэлбэрийн ажлыг сумд, үйлдвэр, аж ахуй, соёл, эрүүдийг хамгаалах зэрэг нийт газруудыг түшиглэж байгаа нам, ХЗЭ, МЗНН зэрэг олон нийтийн байгууллагууд тусгай төлөвлөгөөтэйгөөр зохиох нь чухал байна.

Уламжлалт найрамдлын сарын ажлыг МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жил, Октябрийн Социалист Хувьсгалын 57 жилийн түүхт ойнүүдуг угтаж энэ оны эцсийн улирлын төлөвлөгөөт зорилтууд, уралдаанд авсан үүрэг, өвлийн бэлтгэл ажлыг хангах, тариа ногоо хураалтын дутууг шуурхай дуусгах зэрэг цаг үеийн ажлуудтай нягт холбож явуулах хэрэгтэй.

ОТОРЧИД

Хавцал, Хөөвөр, Зараа орчим, алсаас уншартан цэнхэрлэх уудам шаргал талын энгээр хонин сүрэг суурь сууриараа цайран ярайж тал нутгийн салхи сэвэлзэнэ.

Замын ойролцоох гэрүүдийг хараад хамт явсан нөхөр маань, энэ чинь манай бригадын аварга хончин Цэвэгдорж, Батсүх нар 700—1050 хоньтой, Дорж, Цэдэн нар 1500 гаруй бог малтай хотгүй отор хийж яваа юм. Эд нар агь, нүдлэж яргуй дэлгэрэх хавраас өвсний сөл тасаргал отроор явдаг.

Өнөө жилийн хувьд хонь нэг бүрийг 15—25 кг-аар жингийг нь нэмэгдүүлэх зорилт тавин үр дүнийг нь үзэхээр аль сорог сэрмүүн бэлчээр сонгон нутаглаж яваа нь энэ гэлээ.

Хонин сүрэгтээ тарга хүч авахуулахаар Баян сумын Монгол—Польшийн найрамдал нэгдлийн «Цант» бригадын оторчид ийнхүү шамдаж байна.

Д. ОТГОН

ХОЛБООЧДЫН АМЖИЛТ

Аймгийн холбооны газрын хамт олон 9 дүгээр сарын орлогын төлөвлөгөөг 116,1 хувиар биелүүлсний дотор телефон, шуудан, радио, цахилгаан тасгууд төлөвлөгөөгөө 41,5—105,4 хувиар давуулан биелүүлж Монгол-Зөвлөлтийн найрамдлын уламжлалт сарын ажлыг хөдөлмөрийн сайхан амжилтаар угтлаа.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

БӨӨРӨЛЖҮҮТИЙН НАМАР (СУРВАЛЖЛАГА)

Нүд алдам цэлийх Бөөрөлжүүтийн хөндий өнөө намар алтан шаргал өнгөөр гялбалзан харагдана. Хаана л бол аварга комбайнууд ургацын далайд сэлүүрдэн яваа нь аварга хүнт хөлөг адил.

Төвш дүүрэн тариа агсан машинууд талбайгаас утрэм, утрэмээс талбай руу давхилдана.

Утрэмд буусан тариа алтга өнгөөр шаргалтан дүнхийнэ.

Тариа цэвэрлэгч,ялгагч,

БНМАУ-ын ХАА-н Яамны коллеги, ХАА-н Ажилчдын ҮЭ-ийн Төв Хорооноос хамтран бүх ард түмний социалист уралдааны жил-1974 онд багсармал ба сүү орлох тэжээл үйлдвэрлэх төлөв, лөгөөг хугацаанд нь тоо чанарын үзүүлэлтээр биелүүлсэн тэжээлийн үйлдвэр, био-комбинат, засварын газруудыг шалгаруулан шагнах болзол зарласан билээ.

Уг болзолд заасан бүх үзүүлэлтүүдийг биелүүлсэн Баянцогтын САА-н тэжээлийн үйлдвэрийг I дүгээр байр эзлүүлэн ХАА-н Яам,ХАА-н Ажилчдын ҮЭ-ийн Төв Хорооны диплом,5000 төгрөгөөр шагнав. Уг шагналыг гардуулах нуглаан саяхан сум САА-н төвд болов. Цуглааныг САА-н намын хорооны нарийн бичгийн дарга Цэнд-Аюуш нээж, ХАА-н Ажилчдын ҮЭ-ийн Төв Хорооны нарийн бичгийн дарга Баярт тус

үйлдвэрийн ерөнхий инженер Б.Гунгаад уг шагналыг гардуулан өглөө.

Дараа нь үйлдвэрийн хамт олныг төлөөлж инженер Гунгаа,элжийн мас тер Б.Лхагвадэмбэрэл, ажилчин Дуламсүрэн нар уг хэлж үүрэг амлалт авав. Инженер Гунгаа хэлэхдээ:

—Манай үйлдвэрийн хамт олон эхний хагас жилд сүү орлох тэжээл үйлдвэрлэх төлөвлөгөөг 105 хувь, багсармал тэжээл үйлдвэрлэх төлөвлөгөөг хугацаанд нь 101-110 хувиар тус тус биелүүлсэн амжилтаа улам бататгаж МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн өмнө багсармал тэжээл үйлдвэрлэх сүүлийн хагас жилийн төлөвлөгөөг хугацаанд нь 100—111 хувь биелүүлэхээ илэрхийлжэ гэв.

К.КАПУРАН

АВАРГА КОМБАЙНЧ

Заамар сумын Ар-уртын хөндийд шаргалтан байгаа тариан талбайн захад хүрэхэд 10 гаруй комбайн хоорондоо нийлж хэмжээний зай авч эгнээ эгнээгээрээ ангилсан тариаг цайруулан хурааж явлаа. Комбайнуудын моторын жигдхэн нүргээн дуу тэр хөндийг бүүүвэлж байгаа мэт санагдав. Тариан бригадын дарга Радлан зүүн жигүүрт нь яваа комбайныг зааж, Манай аварга Гончиг тэр явж байна гэв.

Хэдэн мөчийн дараа тэр комбайн талбайн захад гарч ирэхэд богнохон хөвөнтэй хүрэмтэй бор залуу, улаан дарцаг хийсгэсэн СК-3 комбайны жолоон дээрээс бууж ирэв.

Гончиг мэнд усаа мэдэлцэн, ажил өөдрөг байна гэж хариулаад нарсан шинжтэй суудал дороосоо нэг түлхүүр авч комбайн доогуураа орж боолт чангалангаа өгүүлсэн нь:

—Би ноднин жил БНМАУ-ын аварга комбайн-

чин цол хүртсэн. Манай энэ хөндий өгөөж шингэй газардаа. Энэ жил ноднинг гүйцэх ургац алга,гэхдээ манайх I гагаас 10 центнер ургац авахаар тогтоогдсон. Цаг агаар жаахан саадалтай байна.

Өдөрт 40 га газрын тариаг ангилж нийт 320 га газрын тариа хадаж одоо цайруулалтанд явж өдөрт 15—25 га газрын тариа цайруулж нормоо давуулж байна. Миний хувьд аваргынхаа амжилтыг бататгах л зорилттой. Манай нэгдэл улсад тушаах будааныхаа төлөвлөгөөг 100—гаас дээш хувиар биелүүлэх бололцоотой болоо гээд нар жаргаж чийг буухаас өмнө хэд тойроод авья гээд хуйлсан эсгий шиг баалласан тариаг хураахаар тариан талбай руугаа оров.

Ийнхүү БНМАУ-ын аварга комбайнч Гончиг Ар-уртын хөндийн алтан тарианд сэлүүрдэн явна.

Ш.БЯМБАА

вөн жилд гүйцэтгэх зорилт дэвшүүлсэн.

Одоо аж ахуйн хэмжээгээр га тутмаас 13 центнер тариа хурааж байгаагаас үзвэл зорилт хэрэгжиж гавшгайчдын улсын зөвлөлгөөний урналгыг биелүүлэх боломж олоод байна гэлээ.

Өнгөрөгч онд ургацын төлөвлөгөөг 210 хувь биелүүлж ургац хураах талаар зарласан улсын болзлыг хангаж суудлын авто машин, 60 мянган төгрөгөөр шагнуулсан

(Төгсгөл нь II нүүрт)

КОММУНИЗМЫН ОРНЫ АЛХАА

Найрамдал—дружба—достук

(Сэжүүлч, дн замын тэмдэглэл)

Энэ оны 7-р сард Фрунзе хотод болсон их наадамд ажил үйлсээрээ шалгарсан Монгол—Зөвлөлтийн 400 орчим залуус оролцсон юм.

Үүрийн гэгээ дөнгөж хаяарч байсан боловч Чуйн хөндийн ногоон эрдэнэ гэгддэг Фрунзе хотын нисэх онгоцны буудал хүмүүсээр дүүрч энд тэндгүй «найрамдал», «дружба», «достук» гэсэн үг монгол, орос, киргиз хэлээр цуурайтаж байлаа.

Улаанбаатараас зорьж ирсэн найз нөхдөө Киргизийн нийслэлийн охид, хөвгүүд дуу хөгжим, баяр баясгалан, Алатао уулын анхилам цэцгээрээ угтан авлаа. Фрунзе хотын мянга мянган хөдөлмөрчид их наадмын төлөөлөгчдийн явж өнгөрөх гудамж талбай бүхэнд уриа лозун, туг дарцаг, Монгол—Зөвлөлтийн төрийн далбаа барьж «найрамдал» гэсэн үгийг монгол, орос, киргиз хэлээр цуурайтуулж их наадамд оролцогчдод баяр хүргэж нарлаг киргизийн нийслэл баярын чимгээ зүүж их наадмын тэмдэг «найрамдал», «дружба» гэсэн үг, их наадамд оролцогчдод баяр хүргэе гэсэн уриа лозунгаар чимэглэгдсэн байлаа.

Мөнх цаст сарьдаг Алатао уулын хормойгоос холгүй атлаа өвөл, зунгүй нил ногооноороо байдаг нарлаг Фрунзе хотод 19 цаг хэдий болсон авч халууны илч буураагүй байв. 25 мянган хүний суудалтай «Спартак» цэнгэлдэх хүрээлэнд их наадмынхныг орж ирэхэд хөдөлмөрчид халуун дотно угтлаа. Баярын жагсаал явж өнгөрүүт тамирчид цэнгэлдэх хүрээлэнд гимнастик хийж дараа нь Зөвлөлт Киргизийн Лениний Коммунист Залуучуудын Эвлэлийн Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга А.Рысмен-

диев их наадмын ажиллагааг нээж үг хэлэхэд БНМАУ, ЗСБНХУ-ын төрийн дуулал сүр жавхлан тай эгшиглэж их наадмын тугийг өндөрт мандуулав. БХЛКЗЭ-ийн Төв Хорооны нарийн бичгийн дарга Григорьев баяр хүргэж үг хэлсний дараа МХЗЭ-ийн Төв Хорооны хоёрдугаар нарийн бичгийн дарга С. Бадамхатан, МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалаас Монгол—Зөвлөлтийн залуучуудын V их наадамд оролцогчдод ирүүлсэн илгээлтийг уншиж ах дүүгийн чин сэтгэлийн баяр хүргэв.

БНМАУ-ын ардын жүжигчин Норовбанзад мөнгөн аягатай сүү, алд цэнхэр хадгийг их наадмын зохион байгуулах хорооны дарга Киргизийн Коммунист Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Кульматовт өргөн бариллаа.

Нөхөр Кульматов их наадмын хүндэт зочин, ЗХУ-ын нисэх хүчний маршал, Монгол—Зөвлөлтийн баатар Судец нарыг үг хэлэхэд их наадамд оролцогчид халуун дотно хүлээн авав.

Аугаа их эх орны дайны үед амь үрэгдсэн Зөвлөлтийн дайчдын хөшөөний мөнхийн галаас асаасан бамбарыг цэнгэлдэх хүрээлэнд авч ирэхэд цугларгасад суудлаасаа босч алга нижигнүүлэн ташиж угтлаа.

Их наадмын бамбарыг асаахад ёслолын буудлага хийв.

Дараа нь цэнгэлдэх хүрээлэнд үндсний хувцсаа өмссөн улс бүрийн зочид төлөөлөгчид өөрсдийн дуу хөгжмийг тоглож сонирхуулсан нь олны анхаарлыг татлаа.

Их наадмын өдрүүдэд

болсон Зөвлөлт—Монголын залуучуудын туршлага солилцох уулзалт, семинар «дружба», «найрамдал» клубын нээлт, Зөвлөлт—Монгол киноны их наадам, зохиолчдын уулзалт, их наадмын шагналын төлөө уралдаан, найрамдлын сэдэвт уулзалт, цуглаан, үдэшлэг, уран сайхны хамтарсан тоглолт зэрэг олон арга хэмжээнд манай төлөөлөгчид идэвхтэй оролцов.

Их наадмын ажлын хөтөлбөр улс төр, үзэл суртал, соёл урлагийн маш олон талыг хамарч тэр бүгдэд тэгш идэвхтэй оролцсон хоёр орны залуучуудын элч төлөөлөгчид аливаад нэгэн үзэл бодолтой байгаагаа дахин илтгэн харуулсан юм.

Энэ бол Зөвлөлт—Монголын залуу үеийнхэн Марксизм—Ленинизм, пролетарийн интернационализмд болон хоёр орны ард түмний цусаар гагнагдан ах дүүсэг барилдлагаагаар бэхжсэн элгэн халуун найрамдалд чин үнэнч байдгийг яруу тод илтгэн харуудлаа.

Зөвлөлтийн комсомолыг В. И. Лениний нэрэмжит болгосны 50 жил, БНМАУ-ыг тунхагласны хагас зуун жилийн ойд зориулан явуулж байгаа их наадмыг энэ онд тавин жилийнхээ ойг тэмдэглэх гэж байгаа нарлаг Киргиз орны нийслэл үзэсгэлэнт Фрунзе хотод хийсэн нь чухал ач холбогдолтой болов.

Хойноосоо урагшаа 20 км, баруунаасаа зүүн тийш 16 км үргэлжилсэн энэ хот 4000 га талбай эзэлсэн мөнх ногоон ой мод цэцэрлэгт хүрээлэний дунд сүндэрлэж байна. Хотын хүн ам тутамд 100 хавтгай дөрвөлжин метр ногоон ой, цэцэрлэг ноогдон.

Эндэхийн гудамж цэцэрлэгт хүрээлэнгүүдэд далай 300 нэр төрлийн гоёл

чимэглэлийн ба үржимсний мод ургаж байдаг ажээ.

Нйм учраас гадаадын жуулчид тийчид Фрунзе хотыг дэлхийн хамгийн ногоон хотуудын нэг гэж зүй ёсоор нэрлэдэг.

Энэ их ой цэцэрлэг нь зуны асгим халууныг 12 градусаар бууруулж байдаг гэж эрдэмтэд үздэг байна. Фрунзе гэдэг үг бол ногоон навч гэсэн молдав үг юм.

Киргиз улсын нийслэл 1926 оноос эхлэн коммунист нам, Зөвлөлт төрийн шалгарсан зүтгэлтэн, улаан армийн алдарт жанжин, ЗХУ-ын зэвсэгт хүчний авьяас төгөлдөр зохион байгуулагч М. В. Фрунзийн нэрээр нэрлэгдсэн байна.

Фрунзе хот далайн түвшнээс дээш 750—900 м орших бөгөөд эх газрын уур амьсгалтай, өвөл нь дулаан, зун нь халуун юм. Фрунзе хотын хагас сая шахам оршин суугчдын ихэнх нь залуус.

Тиймээс ч Фрунзийг оюутны хот гэдэг нь оносон нэр юм.

Тус хотын 7 дээд, 22 дунд сургуульд 90 мянгад охид, хөвгүүд сурч байна. Нарлаг Киргиз орны хагас зуун жилийн хөгжилт цэцэглэлттэй ташилцахад үнэхээр бахдам.

Одоо Киргизэд 2,5 өдрийн дотор 1913 оны үед бүтэн жилийн турш үйлдвэрлэж байсантай тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Зөвлөлт Киргиз аж үйлдвэрийн 700 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг улс орныхоо эдийн засгийн 40 гаруй районд, 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг дэлхийн 60 орчим оронд нийлүүлж байна.

Алатао уулын 3600 м өндөр Карахорумын даваа давуулан өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам тавьж байгаа, өндөр уулын үзэсгэлэнт

сайхан Иссык-куль нуурын хөвөөгөөр амралтын иж бүрэн таван цогцос барих, 130 км урт услах суваг байгуулах зэрэг бүтээн байгуулалтын аварга том ажил эрчимтэй эхэлсэн байна.

Их наадмын төлөөлөгчид бид Фрунзээс 600 гаруй км аялж Ош мужид хүрэх замдаа онгоцны цонхоор харвал тэртээ дор үүлэн чөлөөгөөр эрдэнэ шиш, тамхи, хөвөнгийн тариалан, хот тосгон үзэгдэх ой мод битүү үргэлжлэн гол горхи урсаж харагдах нь сонин.

Кара-дарьяа мөрнийг нь үзэж, Хараа шороо хэмээх алдарт рашаанаас нь ундаалж, хүний хүч хөдөлмөрөөр сүндэрлэсэн хот тосгон, суваг далан, арвин их урлаг, алим жимсний цэцэрлэг алив бүхнийг нь сонирхон хөвчийн модон дунд ширээ засуулан идээ будаагаар зочлуулж, комуз хөгжмийн аяар цээл сайхнаар дуулж бүжиглэх залуусыг бахдан суухдаа энэ нутгийнхны хичнээн их зочлолтгойг мэдэрт билээ.

Зөвлөлт—Монголын залуучуудын, Зөвлөлдүүдийн оронд хийсэн гурав дахь их наадам ах дүүгийн бат найрамдлын билэг тэмдэг болж өнгөрсөн юм.

Их наадмын өдрүүдэд нарлаг Киргиз орны нарын элч халуун байсан боловч найрамдал нөхөрлөлийн элч тэр бүхнээс халуун байсан.

Найрамдал-дружба-достук энэ гуравхан үг нарлаг Фрунзэд болсон найрамдлын их наадмын есөн өдрийн бүхийл арга хэмжээг багтааж, Монгол—Зөвлөлтийн ард түмэн, түүний залуу үеийнхний ах дүүгийн найрамдлын түүхийн хуудсыг мянгантаа зузаалж өгсөн билээ.

П. ЖАНЧИВ

(Их наадамд оролцсон төлөөлөгч)



Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Грузин Улсын Гардабагжийн районы Джандарийн үржлийн сангийн аж ахуйн хоньчин Латиб Кулиев, сангийн аж ахуйнхаа төргүүний хоньчны нэг юм.

Коммунист залуучуудын эвлэлийн гишүүн Латиб Кулиев 500 хонь малладаг бөгөөд тэрээр саяхан хоньчдын дунд арласан социалист уралдаанд төргүүн байр эзэлжээ.

ТАСС-ын гэрэл зураг.

ЦАГ УЕ МЭДЭЭ • ЦАГ УЕ МЭДЭЭ

ГАНЗАГА ДҮҮРЭН АНЧИН

Залууд талин тэртээд гялалзах цагаан гэрүүдийн гадна ирэхэд анчид оройн гараандаа зөхөж байв.

Бууныхаа замаг юуг тослон, сумаа дайзалж байгаа 40 эргэм насны чийрэг эрийг Дарамбазар гэдэг ажээ.

Хорь шахам жил ангийн олзоор ганзага мялааж байгаа хашир анчин энэ жилийнхээ ихажлыг нугалж байхад нь бид уулзсан юм.

Дарамбазар ярихдаа: —Энэ жил зуншлага сайтай байсан болохоор тарваганы гараа жигд сайн байна.

Би Хөшөөтийн ар,Өвөр мэргэн,Алтганатай, Жаргалантын аманд ан хийдэг. Юуны урьд хувийн бэлтгэлийг жилийн жилд сайн хийдэг.

Ингээд тарвагатай газрыг сонгож агналтаа хийдэг гэлээ.

Дарамбазар энэ жил 300 тарваганы гэрээ хийж 9 дүгээр сарын 20-нд гэрээгээ 102,4 хувиар биедүүлж 50 тарвага илүү агнах үүрэг амлалт аван ажиллаж байна.

Ийнхүү Лүн сумын анчин Дарамбазар ганзага дүүрэн антай явна.

Л. БАТСУХ

“НАЙРАМДАЛ” ХООЛОЙ

Олон улсын нефть дамжуулах «Найрамдал» хоолойн бүтээмж ирэх жил 50 сая тоннд хүрнэ.

Энэ хоолойгоор Польш, БНАГУ, Чехословак, Унгарт Зөвлөлтийн нефть нийлүүлдэг юм.

Нефть дамжуулах хоолой ашиглалтанд орсноос хойших 10 жилийн дотор Польш, БНАГУ уг хоолойгоор 130 сая орчим тонн нефть хүлээн авчээ.

Газар доогуур тавьсан хоолой элдгээр орны нефть боловсруулах, нефть, химийн улам бүр хөгжиж байгаа үйлдвэрийн түүхий эдийн найдвартай бааз байгуулах асуудлыг шийдвэрлэх боломж олгож байна.



ХӨРӨНГӨТӨН ОРНУУД ДАХЬ АЖИЛ ХАЯХ ТЭМЦЭЛ

Хөрөнгөтөн ертөнцөд ангийн тэмцэл улам хурцдаж байна. 1974 оны I сарын сүүлчээр Брюссель хотод баруун Европын капиталист орнуудын коммунист ажилчны намуудын бага хурал болсон билээ. Энд монопольт засгийн газрын эсрэг зохион байгууллагтайгаар тэмцэх хөдөлмөрчдийн тэмцэл хүчтэй болж байгаа болон ажилчин анги, хөдөлмөрийн сэхээтний үндсэн эрх ашгийг хамгаалах тухай асуудал хэлэлцсэн юм. Бага хурлаас гаргасан тунхаглалд хөрөнгөтөн ертөнцийн хямрал улам бүр гүнзгийрч байгааг тэмдэглэжээ. Үүнийг нотлох баримт олныг дурьдаж болно. АНУ, дэлхийн нилээд баялаг гүрний нэг гэхэд өнөөдөр тэнд нийгмийн зөрчилдөөн улам хурцдаж хүмүүс сая саяар ядууран хоосорч байна. Саяхан «Нью-Йорк пост» сонинд бараг 25 сая америкчууд цалин хөлсгүй шахам, өлсгөлөн гуйланчлалын байдал байгаа тухай мэдээлсэн байна. Мөн Англид 23,3 сая хөдөлмөрчид бүх орны ажлын хөлс төлөлтийн дунджийн

хагастай тэнцэх хэмжээнээс доогуур нөхцөлд хөлс аван ажиллаж байна. Тэгэхэд нөгөө талд нь 268 мянган байчууд жилдээ 23 мянган доллар, тэрч байтугай жилдээ 46—51 мянган долларын ашиг олон баяжиж байгаа жишээтэй байна.

Одоо АНУ—д 5 сая, Англид 1 сая ажилгүйчүүд байгаа нь урьд өмнө Латин Америкийн орнууд болон Италид ажилгүйдэж байснаас давж байна. Хөрөнгөтөн орны ажилчин хүнд, маргааш ажилгүй болох болов уу гэсэн аюул үргэлж тулгарч байна. Нөгөө талаар ажилчдыг хөдөлмөр хамгааллын хамгийн доод нөхцөлд ажиллуулж байна.

Энэ талаар Баруун Германы коммунистуудын «Унзере-цайт» сонинд бичсэнээс үзвэл: Тус оронд үйлдвэрийн газарт 13 сая хүнд тутамд нэг золгүй явдал тохиолдох ба 3 минут тутамд хөдөлмөрийн чадвараа алдах тахир дуутуу болохоос гадна 2 цаг тутамд хүндээр гэмтэж үхэх эх үүсвэр бий болдог гэжээ. Зөвхөн 1973 онд металл хайлуулагч 15 мянган хүн үйлдвэрлэлийн гэмтэлд оржээ.

Мөн юмны үнэ ихэсч байгаа нь хөрөнгөтөн ор-

ны ажилчдын амьдралын хэмжээг улам доройтуулж байна. Орон сууцны үнэ нэмэгдсэн талаар Английн «Обсервер»-д нийтэлсэнээс үзвэл, орон сууцны хөлс эрс нэмэгдсэнээс болж ажилчид орон сууцнаасаа албан хавчилгаар хөөгдөн гарч хотын хамгийн бөглүү бохир шавар шалбаагт гудмуудад дорой бүдүүлгээр амьдрах болжээ.

Хөрөнгөтөн ертөнцийн байдал үнэн нүүр царай ниймэрхүү байна. Эдгээр хүнд нөхцөл байдлуудаас болж хөгжингүй капиталист орнууд дахь ажил хаялтын тэмцэл түүнд оролцогчдын тоо өсөн нэмэгдсээр байна. Үүнд 1969-1973 онд ажил хаялтад 225 сая хүн оролцжээ. Францад өнгөрөгч оны 12 дугаар сарын эхээр үндэсний ажилчдын боловсролын холбоо, Францын ардчилсан хөдөлмөрийн болон томоохон үйлдвэрчний эвлэл болох Бүх нийтийн хөдөлмөрийн холбооны санаачлагаар коммунистууд, социалистууд зүүний радикалууд ба дэвшилтэт янз бүрийн байгууллагуудыг идэвхтэй оролцуулан өндөр үнийн эсрэг тэмцэх үндэсний өдрийг зохион байгуулжээ.

Мөн энэ оны 6 сард

Францын УЭ-ийн хамгийн том нэгдэл болох Бүх нийтийн хөдөлмөрийн холбооноос нийгэм эдийн засгийн талаар шаардсан албан нот бичгийг тараасан байна.

Энэ бичигт 7 хоногт хөдөлмөрлөх өдрийн үргэлжлэх хугацааг багасгах, эмэгтэйчүүд, гадаадаас нүүдлэн ирсэн ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрэгтэйчүүд 60, эмэгтэйчүүд 55 насандаа тэтгэвэрт гаргаж журам тогтоолгох зэргийн төлөө шийдвэртэй тэмцэл явуулахыг уриалжээ.

Ангилд өнгөрсөн оны 3-р сард 750 мянган хүн ажил хаясан ба цаашид тэмцэл өсөн 11 дүгээр сарын 12-нд 270 мянган уурхайнд ажлын хөлсийг нэмэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах шаардлага тавин тэмцсээр 1974 оны 3-р сарын 6-нд ажил хаялт ялалтаар төгсчээ.

ХБНГУ-д энэ оны 2-р сард Нюрнберге ба Мюнхенд олон мянган хүний хурал цуглаан сүрт жагсаал болжээ. Мөн 3 дугаар сард конвейрийн системээр ажилладаг 67 том үйлдвэрийн 55 мянган ажилчид олон хоног оор ажиллаагүй байна. АНУ-д эхний хагас жилд 3000 гаруй ажил

хаялт болж түүнд 1 сая 600 мянган хүн оролцжээ. Мөн 7 дугаар сарын дундуур өнгөт металлургийн 30000 ажилчид ажлаа бүрэн зогсоосон байна. Одоо Скандиновын орнууд болон Америк тивд ажил хаях тэмцэл улам өсөн нэмэгдсээр байна.

Хөрөнгөтөн орнууд дахь коммунист ажилчны намууд, УЭ болон нийгмийн бусад байгууллагууд нэгдэн нягтарч хөдөлмөрчдийн үндсэн эрх ашгийн төлөө тэмцэх, империализмын эсрэг фронт улам өргөжин бэхжсээр байна.

Мөн түүнчлэн орчин үед коммунист намууд монополийн эсрэг холбоог өргөнөөр байгуулахын төлөө хөдөлгөөнийг удирдан чиглүүлэгч гол хүчин болж байна.

Тэдгээр намууд монопольт төрийн эсрэг тэмцэлд зүүний бүх хүчийг нэгтгэн нягтруулж байгаагаас гадна хөдөлмөрчдийн өргөн давхрагын хувьсгалт ухамсарыг өргөжүүлэн тэдэнд улс төрийн нь зорилгыг ойлгуулан таниулж байна.

Орчин үед өөрийн эгнээндээ 151 сая хүнийг нэгтгэсэн дэлхийн УЭ-ийн холбоо хөдөлмөрчдийн интернационалист эвнэгдлийг батжуулан бэхжүүлэхэд маш их хувь нэмэр оруулж байна.

Г.БЯМБАРЕНЧИН



Хөдөлмөрчдийн хууль ЗҮЙН МЭДЛЭГТ

СОЦИАЛИСТ ХУУЛИЙН ХҮМҮҮЖҮҮЛЭХ НӨЛӨӨ

Манай социалист хуулийн мөн чанар нь иргэдээ хүмүүжүүлэн зохион байгуулах намын бодлогын илрэл бөгөөд социализм байгуулах үндсэн аргын нэг бол төрийн хууль дүрмийг иргэдэд итгүүлэн ухамсарлуулах явдал мөн.

Монголын ард түмний санаа зоригийн илрэл болсон БНМАУ-ын үндсэн хуульд, социалист эх орныхоо эд баялаг, хүчин чадлыг зузаатгах, хөдөлмөрчин олон түмний чинээлэг аж байдлыг дээшлүүлэх эх сурвалж бол иргэдийн үнэнч шударга хөдөлмөр гэж тодорхойлоод бүх хүч чадал оюун мэдлэгээ эх орондоо социализм байгуулах үйлт зориулах, хууль дүрмийг ёсчлон биелүүлэх, хөдөлмөрийн сахилгыг чандлан сахих, хэв журмыг даган, нийгэмд харш аливаа үзэгдэлтэй шийдвэртэй тэмцэж социалист ёмчийг хайрлан хамгаалж бүхий л аргаар арвижуулахыг заасан байдаг.

Үндсэн хуулийн энэ заалт тус улсын бусад хуульд бүрэн тусгалаа олсон бөгөөд БНМАУ-ын эрүүгийн хуулиар, социалист төрийн эсрэг элдэв үйл ажиллагааг явуулах, улс хоршоолол, олон нийтийн өмч хөрөнгийг ашиглан үрэгдүүлж, шамшигдуулах, социалист аж ахуйд хохирол учруулах, иргэдийн амь бие эрүүл мэнд эрх чөлөө, нэр алдарт харш аливаа гэмт хэрэг үйлдэгчдэд эрүүгийн хариуцлагыг хүлээлэгдэг. Тэгэхдээ манай төрийн хуулиар тогтоогдсон албалагын арга хэмжээ нь засан хүмүүжүүлэх шинж чанартай юм.

Эрүү, иргэн, хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжоор тогтоогдсон арга хэмжээнүүд нь цөм хүнийг хүмүүжүүлэх нэгэн зорилгод чиглэгддэг. Хүнийг тамлан тарчлаах, хүн ёсноос гадуур гутаан доромжлоход чиглэсэн ямар ч арга хэмжээ байхгүй бөгөөд энэ нь манай хуулийн гүн энэрэн-

гүй бөгөөд хүнийг хүмүүжүүлэх үндсэн агуулгын баталгаа юм. Социалист хууль ёсыг хэлбэрэлтгүй биелүүлэх явдал нь гагцхүү хууль дүрмийг иргэдээс хир гүнзгий судалж ойлгосноос шалтгаалах учраас хөдөлмөрчдийг хууль эрхийн мэдлэгээр зэвсэглэхийн ач холбогдол маш их юм. МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1974 оны 24 дүгээр тогтоолд гэмт хэрэгтэй тэмцэх, хууль дүрмийг сурталчлах, хүмүүсийн хууль эрхийн мэдлэг хүмүүжлийг дээшлүүлэх, хуулийн хүчин чадлыг дээд хэмжээгээр зөв ашиглахыг онцлон заасан билээ.

Гэтэл зарим байгууллага хүмүүс хууль сурталчлах ажлын нийгэм улс төрийн ач холбогдлыг дуутуу үнэлж үүнийг зөвхөн засаг захиргаа, хуулийн байгууллагуудын хувьд ноогдсон үүрэг мэтээр үзэх явдал байгааг эцэс болгох хэрэгтэй.

Ялангуяа өсвөрийн залуу үеийнхний дунд зохиох хүмүүжлийн ажлыг тэднээс хууль мэдэх, хууль биелүүлж сурахад чиглүүлэн үндсээр нь сайжруулах нь чухал байна.

Социалист хуулийн хүмүүжүүлэх ролийг бүх аргаар дээшлүүлэх замаар гэмт хэрэг, хэв журмын

зөрчилтэй тэмцэх эрчмийг нэмэгдүүлж эх орондоо социализм байгуулж дуусгах түүхэн том үйлт хувь

нэмэр оруулахын төлөө бүх нийтээр хүч анхаарлаа дайчлав.

Д. ВААНЧИГ

„МАЗ“ МАРКИЙН МАШИНУУД

Минскийн авто заводын үйлдвэрлэсэн 30 гаруй мянган машиныг дэлхийн 50 шахам оронд ашиглаж байгаагийн 10 мянга гаруй нь сайжруулсан хайрцгийн МАЗ-500 маркийн машин юм. Энэ бол чухал бүх үзүүлэлтээрээ өөрийн төрлийн гадаадын аль ч ачааны машинаас идүү сайн болсон машин юм.

Цагт 85 километр хүртэл хурдалдаг, 8,5 тонны даацтай, жолооны механизм нь усан шахууртай, хүч нэмэгдүүлэгчтэй.

Суудлыг нь өндөрсгөж намсгаж болно. Бүхээг нь бас унтах аятайхан суудалтай. Их засварт орлоо эдлэгдэх хугацаа бараг хоёр дахин ихэсчээ. Өөрөөр хэлбэл 200—

220 мянган километр гүйж байж засварт орно.

МАЗ—500 маркийн автомашинуудыг улс ардын аж ахуйд нэвтрүүлсэн нь 40 сая гаруй рублийн эдийн засгийн үр ашиг өгчээ.

Даац ихтэй энэ машиныг удахгүй бөөнөөр үйлдвэрлэж эхэлнэ. Ийм машин улам бүр шинэ зорилт шийдвэрлэх болж байна. Тухайлбал ЭЗХ ТЗ—ийн гишүүн орнуудтай хоршоолон хоёр, гурван голтой их даацтай олон янзын машин бүт болгох талаар ажиллаж байна. Минскийн автомашин үйлдвэрлэгчид бүтээлч эрэл хайгуулаа үргэлжлүүлж байна.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ

ЗАРЛАЛ

Баянцагаан сумын харъяат Сосорбарам овогтой Лайжинханд нь иргэний 317472 номерын үнэмлэхээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.